



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/149/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 201  
танай 2025.01.24 -ны № 3 -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Х.НАРАНТУЯА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

#### Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022057

### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 9 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 95.3 хувьтай үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>328,365,166.04</b>	<b>448,048,548.40</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	155,684,758.36	255,813,798.72
<b>31211</b>	<b>Төрийн сангийн харилцах</b>	155,684,758.36	255,813,798.72
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	172,680,407.68	192,234,749.68
35410	Бичиг хэргийн материал		38,000.00
35420	Аж ахуйн материал	366,350.00	
35470	Бусад хангамжийн материал	172,314,057.68	192,196,749.68
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,206,795,540.42</b>	<b>2,174,760,491.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,955,945,540.42</b>	<b>1,923,910,491.59</b>
391	Газар	250,850,000.00	250,850,000.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,231,048,728.34	2,251,529,895.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,114,090,660.84	2,114,090,660.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(218,215,558.20)	(265,660,085.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,836,961.50	83,296,870.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,558,741.55)	(54,530,061.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,121,106.00	54,142,363.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,398,710.84)	(46,378,422.60)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	91,973,801.00	91,973,801.00
39301	Програм хангамж	1,413,500.00	1,413,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,413,500.00)	(1,413,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,973,801.00	91,973,801.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(46,903,978.33)	(53,024,635.65)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,535,160,706.46</b>	<b>2,622,809,039.99</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	600,973,993.50	600,973,993.50
51210	Өмнөх үеийн үр дүн	219,008,953.55	219,008,953.55
51220	Тайлант үеийн үр дүн		87,648,333.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,715,177,759.41	1,715,177,759.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,535,160,706.46</b>	<b>2,622,809,039.99</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,108,513,387.30</b>	<b>1,322,731,317.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>79,743,487.30</b>	<b>32,389,617.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	67,438,406.00	22,115,167.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	12,305,081.30	10,274,450.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,028,769,900.00</b>	<b>1,290,341,700.00</b>
<b>131001</b>	<b>Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Улсын төсөв/</b>	<b>978,639,900.00</b>	<b>1,243,451,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	50,130,000.00	46,890,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	599,957,834.17	865,075,480.13
210101	Үндсэн цалин	431,103,506.10	593,026,135.13
210102	Нэмэгдэл	148,328,886.07	236,350,717.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		

**Дорнод аймгийн Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210104	Урамшуулал	20,525,442.00	35,698,628.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,817,020.75</b>	<b>106,268,027.51</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,174,666.26	72,794,617.41
210202	Тэтгэмжийн даатгал	5,996,442.10	8,551,511.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,776,185.63	5,740,498.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,169,909.85	2,658,274.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,699,816.91	16,523,125.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,393,860.44</b>	<b>45,285,826.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,222,177.48	11,138,054.22
210302	Түлш, халаалт	17,442,941.96	19,511,166.01
210303	Цэвэр, бохир ус	10,728,741.00	14,636,606.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,580,082.00</b>	<b>4,802,258.00</b>
210408	Бараа материал акталсны зардал	5,580,082.00	4,802,258.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>117,660,027.50</b>	<b>130,351,530.00</b>
210502	Хоол, хүнс	117,660,027.50	130,351,530.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>724,503.00</b>	<b>1,600,000.00</b>
210604	Урсгал засвар	724,503.00	1,600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,080,000.00</b>	<b>2,080,556.00</b>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,080,000.00	2,080,556.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>79,009,470.65</b>	<b>76,615,131.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,430,700.73	16,382,916.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,010,900.00	1,682,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,567,869.92	58,550,215.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,023,500.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,023,500.00	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт</b>	<b>11,236,139.56</b>	<b>4,173.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,236,139.56	4,173.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>169,030,949.23</b>	<b>87,648,333.53</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>169,030,949.23</b>	<b>87,648,333.53</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,028,769,900.00</b>	<b>1,290,341,700.00</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,028,769,900.00</b>	<b>1,290,341,700.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,028,769,900.00</b>	<b>1,290,341,700.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>978,639,900.00</b>	<b>1,243,451,700.00</b>
<b>1311</b>	Нэмэлт санхүүжилтийн орлого		
<b>131001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Улсын төсөв/	978,639,900.00	1,243,451,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,130,000.00	46,890,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	50,130,000.00	46,890,000.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>599,957,834.17</b>	<b>865,075,480.13</b>

Дорнод аймгийн Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	431,103,506.10	593,026,135.13
210102	Нэмэгдэл	148,328,886.07	236,350,717.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210103	Урамшуулал	20,525,442.00	35,698,628.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,817,020.75</b>	<b>106,268,027.51</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,174,666.26	72,794,617.41
210202	Тэтгэмжийн даатгал	5,996,442.10	8,551,511.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,776,185.63	5,740,498.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,169,909.85	2,658,274.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,699,816.91	16,523,125.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,393,860.44</b>	<b>45,285,826.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,222,177.48	11,138,054.22
210302	Түлш, халаалт	17,442,941.96	19,511,166.01
210303	Цэвэр, бохир ус	10,728,741.00	14,636,606.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>117,660,027.50</b>	<b>130,351,530.00</b>
210502	Хоол хүнс	117,660,027.50	130,351,530.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>1,600,000.00</b>
210604	Урсгал засвар	2,500,000.00	1,600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,590,000.00</b>	<b>2,080,556.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,590,000.00	2,080,556.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,991,953.73</b>	<b>39,547,066.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,981,053.73	26,120,566.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,010,900.00	13,426,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,259,639.56</b>	<b>4,173.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,023,500.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,023,500.00	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>11,236,139.56</b>	<b>4,173.77</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,236,139.56	4,173.77
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,025,700.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,025,700.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,025,700.00</b>	<b>-</b>
	Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал	<b>6,025,700.00</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,025,700.00)</b>	
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>135,573,863.85</b>	<b>100,129,040.36</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>20,110,894.51</b>	<b>155,684,758.36</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>155,684,758.36</b>	<b>255,813,798.72</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>600,973,993.50</b>	<b>1,715,177,759.41</b>	<b>219,008,953.55</b>	<b>2,535,160,706.46</b>
Тайлант үеийн үр дүн			87,648,333.53	87,648,333.53

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>600,973,993.50</u>	<u>1,715,177,759.41</u>	<u>306,657,287.08</u>	<u>2,622,809,039.99</u>
---------------------------------------	-----------------------	-------------------------	-----------------------	-------------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
21	Урсгал зардлын дүн	1,983,200.00	180,000.00	1,803,200.00
80233	Хүүхэд хамгааллын зардал	1,983,200.00	180,000.00	1,803,200.00
210901	Бараа үйлчилгээний зардал	1,983,200.00	180,000.00	1,803,200.00
21	Урсгал зардлын дүн	3,098,500.00	1,680,000.00	1,418,500.00
81605	Эрүүл мэнд зардал	3,098,500.00	1,680,000.00	1,418,500.00
210901	Бараа үйлчилгээний зардал	3,098,500.00	1,680,000.00	1,418,500.00
21	Урсгал зардлын дүн	5,630,200.00	5,630,200.00	-
81816	Нөхөн хангалтын зардал	5,630,200.00	5,630,200.00	-
210901	Бараа үйлчилгээний зардал	5,630,200.00	5,630,200.00	-
21	Урсгал зардлын дүн	3,501,700.00	3,130,000.00	371,700.00
81823	Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал	3,501,700.00	3,130,000.00	371,700.00
210901	Бараа үйлчилгээний зардал	3,501,700.00	3,130,000.00	371,700.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,078,661,200.00</b>	<b>982,843,530.41</b>	<b>95,817,669.59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,381,700.00	865,075,480.13	83,306,219.87
210101	Үндсэн цалин	678,123,300.00	593,026,135.13	85,097,164.87
210102	Нэмэгдэл	249,260,800.00	236,350,717.00	12,910,083.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-
210104	Урамшуулал	20,997,600.00	35,698,628.00	(14,701,028.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,547,700.00	106,268,027.51	12,279,672.49
210201	Тэтгэврийн даатгал	80,612,400.00	72,794,617.41	7,817,782.59
210202	Тэтгэмжийн даатгал	9,483,800.00	8,551,511.91	932,288.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,741,900.00	5,740,498.79	(998,598.79)
210204	Ажилгүйдлийн даатгал	4,741,900.00	2,658,274.00	2,083,626.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,967,700.00	16,523,125.40	2,444,574.60
210502	Хоол хүнс	117,660,027.50	130,351,530.00	(12,691,502.50)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,655,300.00	2,080,556.00	2,574,744.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	4,655,300.00	2,080,556.00	2,574,744.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,927,200.00	28,926,866.00	334.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,500,400.00	15,500,366.00	34.00
210902	Хичээл үйлдвэрлэл дадлага хийх	13,426,800.00	13,426,500.00	300.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮҮСВЭР</b>	<b>ЭХ</b>	1,264,645,600.00	1,243,451,700.00	21,193,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		1,264,645,600.00	1,243,451,700.00	21,193,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		1,108,961,100.00	1,243,451,700.00	(134,490,600.00)
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		155,684,500.00		155,684,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			155,684,758.36	(155,684,758.36)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			255,813,798.72	(255,813,798.72)
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>		39.00	41.00	
620001	Удирдах ажилтан		1.00	1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан		24.00	25.00	
620003	Үйлчлэх ажилтан		14.00	15.00	

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
122005	Төсвөөс санхүүжих	<b>46,890,000.00</b>	<b>46,890,000.00</b>	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	46,890,000.00	46,890,000.00	-
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	46,890,000.00	46,890,000.00	-
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>46,890,000.00</b>	<b>46,885,826.23</b>	<b>4,173.77</b>
<b>2103</b>	<b>БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>	<b>45,290,000.00</b>	<b>45,285,826.23</b>	<b>4,173.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	<b>10,668,900.00</b>	<b>11,138,054.22</b>	<b>(469,154.22)</b>
21302	Түлш халаалт	16,917,100.00	19,511,166.01	<b>(2,594,066.01)</b>
21303	Цэвэр, бохир ус	17,704,000.00	14,636,606.00	<b>3,067,394.00</b>
	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>1,600,000.00</b>	<b>1,600,000.00</b>	-
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	-
<b>26</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>			-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		<b>4,173.77</b>	

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 130.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, няравт нарт тус бүр 150.0 хувиар тооцон 3.5 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тендерээр худалдан авалтын 126.7 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно, 48 дугаар зүйлийн 48.2.9-д Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 150.0 хувиар олгосон	1	3,504.0			1	3,504.0						
Тендерээр худалдан авалтын 126.7 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн	1	126,657.3			1	126,657.3						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>130,161.3</b>			<b>2</b>	<b>130,161.3</b>						



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 165/19425749  
ДАА-2025/1140/НА-СТА-МУЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3,504,000.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040433

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Х.Нарантуяа, нягтлан бодогч Э.Насанжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 168/1912.5799  
ДДА-2025/149/НА-СТА-ТМБ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 126,657,300.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ хууль тогтоомжийг мөрдөөгүй, холбогдох нотлох баримтыг хангалттай бүрдүүлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх” зарчим, 48 дугаар зүйлийн 48.2.7-т “Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, 48.2.9-т “Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах”, 47.3-т “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 дэх “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”, 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040434

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Х.Нарантуяа, нягтлан бодогч Э.Насанжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

